



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

**Баянзүрх дүүргийн “Нийтлэг
үйлчилгээний газар гурав”
ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс
эргэлтийн бус хөрөнгө хасах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 14,975,646 /арван дөрвөн сая есөн зуун далан таван мянга зургаан зуун дөчин зургаа/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар гурав” ОНӨААТҮГ /Х.Өлзийхорол/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 6,463,586 /зургаан сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун наян зургаан/ төгрөгийн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 8,512,060 /найман сая таван зуун арван хоёр мянга жаран/ төгрөгийн хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар гурав” ОНӨААТҮГ /Х.Өлзийхорол/-т даалгасугай.

3. Татан төвлөрүүлэх хөрөнгийг төвлөрүүлэн үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ОДНАСАН

D:\Tushaal-2019\Tushaal-1\Тушаал 2019.docx

115050000327

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны ...05...сарын
07 өдрийн 1/88 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар гурав ОНӨААТҮГ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл Үнэ	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Канон sharf 5618	5	ш	1	1,525,000	1,525,000	1,525,000	0	татах
2	Компьютер HASEE	5	ш	4	950,000	3,800,000	3,800,000	0	татах
3	Принтер samsung	4	ш	1	111,150	111,150	111,150	0	татах
4	Интернет төхөөрөмж	4	ш	2	208,000	416,000	416,000	0	татах
5	Кофе чанагч	4	ш	1	700,000	700,000	700,000	0	татах
6	Өнгөт принтер epson l 211	4	ш	1	498,000	498,000	498,000	0	татах
7	Зургийн аппарат	4	ш	1	350,000	350,000	350,000	0	устгах
8	Samsung notebook	4	ш	2	980,000	1,960,000	1,960,000	0	устгах
9	Процессор /GPS /	4	ш	1	520,000	520,000	520,000	0	устгах
10	Зургийн аппарат	4	ш	1	200,000	200,000	200,000	0	устгах
11	Процессор DELL OPTIFLEX 330	4	ш	1	249,920	249,920	249,920	0	татах
12	Дэлгэц DELL 19	4	ш	1	130,000	130,000	130,000	0	татах
13	Принтер SAMSUNG ML2165W	4	ш	1	149,990	149,990	149,990	0	татах
	Тоног төхөөрөмжийн дүн			18	6,572,060	10,610,060	10,610,060	0	
14	Ширээ BE140	10	ш	1	119,780	119,780	119,780	0	устгах
15	Сандал Хар	10	ш	1	108,790	108,790	108,790	0	устгах

16	Тумбочка дугуйтай	10	ш	1	96,450	96,450	96,450	0	устгах
17	Сандал H22B	10	ш	2	29,110	58,220	58,220	0	устгах
18	Бичгийн ширээ	10	ш	2	280,000	560,000	560,000	0	устгах
19	Зөвлөгөөний ширээ	10	ш	2	210,000	420,000	420,000	0	устгах
20	Онгорхой шүүгээ	10	ш	2	132,273	264,546	264,546	0	устгах
21	Шилэн хаалгатай шкаф	10	ш	2	322,000	644,000	644,000	0	татах
22	Жижиг ширээ	10	ш	2	90,000	180,000	180,000	0	устгах
23	Сандал	10	ш	16	16,800	268,800	268,800	0	устгах
24	Төмөр сейф	10	ш	2	144,000	288,000	288,000	0	татах
25	Ширээ	10	ш	2	196,000	392,000	392,000	0	устгах
	Тавилга эд хогшил хогшлын дүн			35	1,745,203	3,400,586	3,400,586		
26	Санхүүгийн программ	4	ш	1	680,000	680,000	680,000	0	устгах
27	Няравын программ	4	ш	1	285,000	285,000	285,000	0	устгах
	Биет бус хөрөнгийн дүн			2	965,000	965,000	965,000	0	
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн			55	9,282,263	14,975,646	14,975,646	-	
Үүнээс: Худалдах хөрөнгө									
Актлах хөрөнгө						6,463,586	6,463,586		
Татан төвлөрүүлэх хөрөнгө						8,512,060	8,512,060		
Худалдсанаас олох орлого									
НӨХГ-т төвлөрүүлэх /30%/									